

## Хяналт шалгалтын танилцуулага

2024 09 25

Шалгалтын зорилго: Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 05 сарын 08 өдрийн 1304/01/101/А 1370327/ ЗАА-2022/01/ ШТА-ГА тоот албан шаардлага, Холбогдох хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам стандарт тогтоол, шийдвэрийн хэрэгжилт осол аваар, хүрээлэн буй орчны бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулах, таслан оршино.

### Шалгалтын бүрэлдхүүн, хугацаа

Шалгалтыг 2024 оны 07 сарын 20 өдрөөс 09 сарын 25 өдөр хүртэл БОХУБ Ц. Баянмөнх ахлаж, Багийн Засаг дарга М.Баянмөнх Газрын даамал Д.Даваадорж Байгаль хамгаалагч Бямбаноров нарын бүрэлдхүүнтэй хийж гүйцэтгэв.

### Шалгалтанд хамрагдах асуудалууд

Шалгалтыг № 01.1.6 кодтой хяналт шалгалтын хуудасанд заагдсан асуудлын дагуу шалгав.

### Шалгалтанд хамрагдсан объектын товч мэдээлэл.

Тус сумын төвд одоогоор ажиллаж байгаа төвлөрсөн уурын зуухыг 2019-2020 онд Ти Жи Өү Жи ХХК нь сум аймгийн орон нутгийн сангийн хөгжлийн хөрөнгө оруулалтаар барьж гүйцэтгэн одоо үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

Сумын ЗДТГ, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, ЕБС, дотуур байр, хүн эмнэлэг Соёлын төв гэсэн 7 объектыг дулаанаар хангадаг.

Суманд 8 байгаль хамгаалагч ажилладаг. Өмнө шалгалтанд хамрагдаж байгаагүй.

### Шалгалтын явцад хийгдсэн ажил шийдвэрлэсэн асуудал

Шалгалтыг тус уурын зуухны байранд гүйцэтгэх захирал Б.Гантуяа, галч Б.Дагвачүлтэм нарыг байлцуулан уурын зуухны холбогдох бичиг баримттай танилцан хяналтын хуудасын дагуу шалгахад дараахь зөрчил илэрлээ.